

Амар амгаланг мэдрүүлэх Куба орон

Карибийн тэнгисийн эрэг дээр орших Куба улсаар зочлоход зөөлөн дулаан уур амьсгал, найрсаг харилцаатай нутгийн иргэд угтана. Тус улсын нийслэл Гавана хот жуулчдын хувьд үзэж харах зүйлсээр баялаг. Хуучны автомашинуудын өнгө будгийг сэргээж Гаванаг зорин ирэгсдэд үйлчилдэг болсон нь Куба улсад зочилсон хүмүүсийн анхаарлыг татна. Тэдгээр автомашины жолооч нар хүмүүстэй голдуу англи хэлээр харилцах бөгөөд хотоо танилцуулах маршрут гарган жуулчдад эх орныхоо өнгөрсөн болон одоогийн сонин хачнаас тайлбарлан таниулдаг байна. Карибийн тэнгисийн эрх чөлөөний арал улс Кубын тухай товч өгүүлье.

Гавана хотын

Бяцхан түүх

Гавана нь Куба улсын нийслэл хот бөгөөд эдийн засаг, худалдааны томоохон боомт хот юм. Тус хот хоёр сая гаруй оршин суугчтай, Карибийн тэнгисийн бүсдээ гуравдагч том хотод ордог. Гавана хотыг XVI зуунд испаничууд байгуулжээ. Тодруулбал, 1492 оны аравдугаар сарын 12-нд Бараккогийн ойролцоо Кристофер Колумб бууж "Испанийн хаант улсын шинэ арал" хэмээн зарласан байдаг. Испанийн анхны сууринг 1511 онд байгуулж, дөрвөн жилийн дараа ирээдүйн нийслэл Гавана хотын суурийг тавьсан түүхтэй.



Хотын төвийн содон барилга

Гавана хотод түүхийн гэрч болсон нэгэн барилга байдаг нь Капитолио (Capitolio) юм. Харахад Америкийн Цагаан ордонтой адилхан ч Францын Пантеоны загвараар бүтээн байгуулсан уг барилгыг 1926 онд барьжээ. Энд 1959-2013 онд шинжлэх ухаан, мэдээллийн төв болон номын сан байрладаг байсан аж. Харин одоо Капитолиог сэргээн засварлаж байгаа бөгөөд 2018 онд засварын ажил дуусах юм байна.



Хамгийн алдартай нь Варадеро

Варадеро нь Куба улсын хамгийн алдартай амралт, зугаалгын бүс юм. Тус улсын Матанзас мужийн Хикакосын хойгт байрлах энэхүү газар нийслэл хотоосоо 130 километр оршино. Хикакосын хойгт 100 гаруй зочид буудал, олон улсын нисэх онгоцны буудал үйл ажиллагаагаа явуулдаг. Куба улсыг жилд таван сая жуулчин зорин очдог гэж тооцвол, тэдгээрийн 45 хувийг Варадеро дангаараа хүлээн авдаг ажээ. Варадеро амралтын бүс цав цагаан элс, номин хөх ус бүхий наран шарлагын газраараа дэлхийд алдартай. Энэхүү наран шарлагын газрын нийт урт 22 километр.




Үзэсгэлэнт Виньялес

ЮНЕСКО-ийн соёлын өвд бүртгэгдсэн байгалийн үзэсгэлэнт газруудын нэг нь Виньялес юм. Энд Куба улсын Ерөнхийлөгч асан Фидель Кастро очих дуртай байжээ.

Амар амгаланг мэдэрч болох Виньялесээс дэлхийн шилдэг сортын навчин тамхи авч болно. Мөн навчин тамхийг хэрхэн хийдгийг эндээс харах боломжтой.

Жон Ленноны хөшөөг зорин огоорой

Куба улсад алдарт “Битлз” хамтлагийн Жон Ленноны хөшөө байдаг гэвэл та итгэх үү. Тэгвэл түүний нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн нийслэлд нь байдаг аж. Хэн нэгнийг хүлээж суугаа мэт дүрсэлсэн Жон Ленноны хөшөөг харахад нэг л зүйл анхаарал татна. Учир нь түүний баримал нүдний шилгүй байх аж. Жон Ленноныг анх нүдний шилтэйгээр урласан ч цэцэрлэгт хүрээлэнгээр зочилсон хүмүүс авчихдаг юм байна. Тиймээс л түүний баримал одоо болтол нүдний шилгүй байгаа аж.



Эрнест Хэмингуэйн алдаршуулсан уушийн газар

Та Куба улсад аялж байхдаа Эрнест Хэмингуэйн гар бичмэлтэй уушийн газраар зочлох боломжтой. Тэдгээрийн нэг нь “La Bodeguita Del Medio” буюу алдарт зохиолчийн мохито уудаг байсан уушийн газар юм. Энд Нобелийн шагналт зохиолч зөвхөн мохито амтлахаар ирдэг байжээ. Мохито гэдэг нь ром дарс, гаа, лаймын шүүс, хийжүүлсэн ус болон элсэн чихэртэй сэнгэнэсэн амттай коктейль юм. Энэхүү газраас 15 километрийн зайд Эрнест Хэмингуэйд зориулсан гэр музей байдаг ажээ.



Үндэсний хөгжим нь сон

Кубачууд дуу, хөгжим, бүжгээрээ маш алдартай. Үндэсний сон хөгжим нь салса, румба болон мамбо бүжгийн суурь ажээ. Тэдгээрээс румба нь Гавана хотоос зүүн зүгт машинаар ганц цаг л яваад хүрдэг Матанзас хэмээх боомт хотод XIX зууны сүүлчээр үүссэн румба бөмбөрт суурилсан конго хөгжим, фламенго маягийн дуулалт, африк бүжгийн хөдөлгөөнийг хослуулсан бүжиг юм. Уламжлалт румба 1950-аад оноос бүс нутагтаа дэлгэрчээ.